



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/Н/З

Чингис хот

Малын шилжилт хөдөлгөөний, отор
нүүдлийг хязгаарлах, гоц халдварт өвчнөөс
урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2.1, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолын "Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах тухай" нэгдүгээр хавсралт зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт өвчин оношлогдсонтой холбогдуулан бусад аймгаас Хэнтий аймгийн нутагт чиглэсэн малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдлийг гоц халдварт өвчнийг бүрэн хяналтад авах хүртэлх хугацаанд зогсоосугай.

2. Малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдэлд хяналт тавих зорилгоор Цэнхэрмандал сумын Хэрлэнгийн гүүрэн дээр хяналтын пост байгуулж ажиллах ажлын хэсгийн ахлагчаар Мал эмнэлгийн газрын дарга Н.Анхбаяр, гишүүдээр аймгийн Цагдаагийн газрын дарга хурандаа Б.Батсайхан, Онцгой байдлын газрын дарга хурандаа Ж.Эрдэнэбат, Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Сүнгээ, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Энх-Амгалан нарыг тус тус томилсугай.

3. Дээрх хугацаанд хяналтын постод шаардагдах зардлыг гаргаж танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Анхбаяр)-д даалгасугай.

4. Жаргалтхаан, Мөрөн, Баянмөнх, Баян-Овоо сумдад малын гоц халдварт өвчин оношлогдсонтой холбоотойгоор голомтод халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэх, багийн хэмжээнд хорио цээрийн дэглэм тогтоох, гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг дээрх сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Шүлхий өвчин оношлогдсон Жаргалтхаан сумын Баян-Эрдэнэ баг, Баянцогт баг, Баянмөнх сумын Хэрлэн баг, Мөрөн сумын Өлзийт багийн нутаг дэвсгэрээс мал малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, Баян-Овоо сумын үхэр, түүний гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд гоц халдварт өвчнийг бүрэн хяналтад авах хүртэлх хугацаанд мал эмнэлгийн нэгдсэн системээс цахим мал эмнэлгийн гэрчилгээ олгохгүй байхыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж болон сумдын мал эмнэлгийн тасагт даалгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр), Цагдаагийн газрын дарга (Б.Батсайхан), хориглосон сумдын багт хууль бусаар мал эмнэлгийн гэрчилгээ олгох асуудал дээр хяналт тавьж ажиллахыг

23101/120

2.

аймгийн Тагнуулын хэлтсийн дарга (Н.Алтангэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

6. Улсын хэмжээнд гоц халдварт өвчний эрсдэл өндөр байгаатай холбогдуулан мал, амьтны гоц халдварт шүлхий, хонины цэцэг, бог малын мялзан, үхрийн арьс товруутах өвчнийг эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, тандалт, мал угаалгын ажлыг 2021 оны 10 дугаар сарын 01-ний дотор шуурхай зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7. Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ зохион байгуулахад мэргэжил арга зүйн заавар зөвлөмж, нэгдсэн удирдлагаар хангаж шаардлагатай вакцин, халдваргүйтгэлийн бодис, хэрэглэгдэхүүнээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т даалгасугай.

8. Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд Баянмөнх, Жаргалтхаан, Мөрөн, Баян-Овоо сумдад тус бүр 2,000,000 (хоёр сая) төгрөг нийт 8,000,000 сая (найман сая) төгрөгийн дэмжлэгийг үзүүлж, Гамшгийн эрсдэлийн сангийн Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх зардлаас санхүүжүүлэхийг Төрийн сангийн хэлтсийн дарга (Нямдаваа)-д даалгасугай.

9. Малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг өндөржүүлэн, малчид, мал бүхий иргэдэд уг захирамжийг танилцуулж, илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгуулах арга хэмжээ авч ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр), бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

10. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ